МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 23/3 Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2023 оны 9 дүгээр сарын 13, 15-ны өдрүүдэд хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдааны эхний өдөр Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, мөнгөний бодлогын хэрэгжилт, банкны салбарын өнөөгийн байдал болон эдийн засгийн өнөөгийн байдлын талаар Монголбанкны хариуцсан газрууд танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Хуралдааны хоёр дахь өдөр эдийн засгийн цаашдын төлөв болон мөнгөний бодлогын саналыг Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас, орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудын талаар Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (НУСЗЗГ)-аас тус тус танилцуулж, хэлэлцүүллээ.

Эхний өдөр Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг танилцуулав. Ирэх онд мөнгөний бодлого нь инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Монгол Улсын эдийн засаг цар тахал, олон улсын геополитикийн зөрчилдөөнөөс үүдэлтэй бэрхшээлийг даван туулж байгаа боловч цаашид гадаад эдийн засгийн орчинд тодорхой бус байдал буурахгүй, гэнэтийн хэлбэлзэл өндөр байх төлөвтэй байна. Иймд Монгол Улс эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэсэн бодлогыг цаашид тууштай үргэлжлүүлэх, энэ хүрээнд инфляцыг дунд хугацаанд 6+/-2 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцыг тогтворжуулах замаар дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлэх, ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх, хил дамнасан худалдааны цахим төлбөр, тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих зэрэгт төвлөрч ажиллахаар тусгалаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу УИХ-аас жил бүр Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн баталдаг болсон. Иймд энэ удаагийн үндсэн чиглэлийн төслийг Монголбанк хуульд заасан өөрийн үндсэн зорилт, чиг үүргийн хүрээнд тодорхойлж, боловсруулсан болохыг онцоллоо.

Хурлын дараагийн хэсэгт мөнгөний бодлогын үйл ажиллагаа, хэрэгжилтийг танилцууллаа. Нүүрсний экспортын орлогоос шалтгаалан гадаад валютын орох урсгал сайжирч, гадаад валютын улсын нөөц 2023 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар оны эхнээс 534 сая ам.доллароор нэмэгдээд байна. Түүнчлэн, төгрөгийн ханш 2023 оны 2 дугаар улиралд чангарч байсан бол 3 дугаар улиралд эдийн засгийн идэвхжил, үүнийг дагасан гадаад валютын эрэлт нэмэгдсэнээр төгрөгийн ханш буцаад суларсан байна. Төгрөгийн ханш суларч эхэлснээр банкуудын төгрөгийн түргэн борлогдох актив буурч, гадаад валютын түргэн борлогдох актив нэмэгджээ. Мөн МБХ-ны 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор заасан ЗБН-өөс хасаж тооцох эх үүсвэрийн[1]

[1] Банкны гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр шинээр татсан 360 хоног хүртэлх хугацаатай эх үүсвэрийг

зохицуулалтын хүрээнд банкууд нийт 37 тэрбум төгрөгтэй тэнцэх эх үүсвэр шинээр татсан байна.

Үргэлжлүүлээд банкны системийн өнөөгийн нөхцөл байдлын тухай танилцуулав. Банкны системийн нийт актив болон пассив харгалзан жилийн 13.7 хувь болон 13.4 хувиар өсжээ. Харин банкны системийн зээлийн үлдэгдэл 2023 оны 2 дугаар улиралд жилийн 7.9 хувиар өссөн бөгөөд өсөлтийг иргэдийн зээл голлон бүрдүүлжээ. Иргэдийн зээл дундаа цалин, тэтгэврийн зээл өндөр өсөлттэй байгааг танилцууллаа. Түүнчлэн, банкны системийн зээлийн чанар тайлант улиралд сайжирсан байна. Тухайлбал, анхаарал хандуулах болон чанаргүй зээл нийт зээлийн харгалзан 5.4 хувь, 8.1 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх улирлаас 0.8, 0.9 нэгж хувиар буурсан байна.

МБХ-ны эхний өдрийн хуралдааны сүүлийн хэсэгт эдийн засгийн өнөөгийн байдал, ойрын төлөвийг танилцуулав. Улаанбаатар хотын инфляц 2023 оны 8 дугаар сард 10 хувьд хүрэхэд дотоодын бараа, үйлчилгээ, тэр дундаа дотоодын хүнсний инфляц дийлэнх хэсгийг нь бүрдүүлж байна. Цаашид инфляц алгуур буурах, энэ оны сүүлийн хагаст 1 оронтой тоонд хүрэх хүлээлт хэвээр байна. Эдийн засгийн өсөлт 2023 оны эхний хагаст 6.4 хувьд хүрч, өсөлтийг уул уурхай болон тээврийн салбар голлон тэтгэж байна. Бусад салбаруудын хувьд бүгд өсөлттэй, зөвхөн мал аж ахуйн салбар уналттай байгааг танилцуулав. Энэ онд нүүрсний экспортын өсөлттэй уялдан уул уурхайн салбарын өсөлт эрчимжих, төсвийн төлөв суларсан нь уул уурхайн бус салбаруудын идэвхжилд эергээр нөлөөлөхөөр байгаа тул эдийн засгийн өсөлтийн төлөв 5.6 хувьд хүрч нэмэгдсэн байна. Цаашлаад мөнгө, зээлийн үзүүлэлтийг танилцууллаа. Гадаад валютын цэвэр орох урсгал нэмэгдэж байгаа нь банкны системийн гадаад цэвэр актив, улмаар М2 мөнгөний жилийн өсөлтийг нэмэгдүүлж байна. Банкны системийн зээлийн өсөлт оны эхнээс алгуур нэмэгдэж байгаа бөгөөд зориулалтаар нь авч үзвэл, хэрэглээний зээл голлон өсөж, бизнесийн зээлийн өсөлт нам түвшинд хэвээр байгааг дурдав. Түүнчлэн, төлбөрийн тэнцэл 2023 оны 2 дугаар улиралд 394 сая ам.долларын ашигтай гарснаар гадаад валютын улсын нөөц үргэлжлэн нэмэгдэж байна.

МБХ-ны хоёр дахь өдрийн хуралдааны эхний хэсэгт МБГ-аас мөнгөний бодлогын саналыг эдийн засгийн суурь төсөөлөл, түүнд ашигласан таамаглалт нөхцөлүүд, хувилбар төсөөллүүдэд үндэслэн танилцууллаа. Төсөөлөлд ашигласан гадаад орчны таамаглалт нөхцлүүдийг авч үзвэл АНУ, Евро бүсийн инфляц буурч байгаа ч зорилтот түвшнээсээ өндөр, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал үргэлжилж, аж үйлдвэрийн салбарын сэргэлт удаашралтай байгаа нь дэлхийн эдийн засгийн төлөв болоод түүхий эдийн үнэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Гадаад худалдааны хувьд хэрэглээ болон аж үйлдвэрлэлийн орцын импорт буурах, нүүрсний экспорт эрчимжиж улмаар төлбөрийн тэнцэл энэ онд ашигтай гарах төлөвтэй байна. Макро эдийн засгийг системийн эрсдлээр нь авч үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин хэвийн үеэс 3 орчим хувиар бага, уул уурхайн бус салбаруудын өсөлт төдийлөн өндөр биш, зээл хадгаламжийн харьцаа бага буюу зээлийн өсөлтийг хангахуйц хадгаламжийн эх үүсвэр хангалтгүй байгаа бол гадаад валютын нөөц богино хугацаат өр төлбөрийн харьцаа, худалдааны тэнцэл сайжрах нь гадаад секторын эмзэг байдлыг бууруулах нөлөөтэй байна.

Үргэлжлүүлэн дотоод эдийн засгийн төлөвийг танилцуулав. Глобал эдийн засагт инфляцын эрч саарснаар импортын барааны үнэ буурч байгаа ч дотоод хүнсний инфляц нийлүүлэлтийн шалтгаантайгаар өсөх, их дээд сургуулийн төлбөр нэмэгдэх, төсвийн тодотголоор цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр эрэлтийн шалтгаантай инфляц

нэмэгдэх тул энэ оны инфляцын төсөөллийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүллээ. Ирэх онд нийлүүлэлтийн шок үүсэхгүй гэж үзвэл нийт инфляц алгуур буурах хандлагатай байна.

Эдийн засгийн өсөлтийн төлөвийг энэ онд өмнөх төсөөллөөс сайжрууллаа. Энэ онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч өсч байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг эрчимжүүлж байна. Үүнтэй уялдан тээврийн салбарын сэргэлт сүүлийн улирлуудад үргэлжлэх, төсвийн тодотголын нөлөөгөөр уул уурхайн бус салбаруудын идэвхжил нэмэгдэнэ гэж үзээд өсөлтийн төлвийг сайжруулав. Ирэх онд төсвийн төлөв сулрах, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбарын өсөлт сэргэх, уул уурхайн салбарын эерэг дам нөлөөгөөр эдийн засгийн өсөлт нэмэгдэхээр байна.

Төсвийн зардал төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдлийн дүнгээр байна гэж үзвэл 2023-24 онд төсвийн төлөв суларч, 2025 оноос чангарах төлөвтэй байна. Мөнгөний үзүүлэлтүүдийн хувьд хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлээс бусад зээлийн өсөлт бага түвшинд байгаа ч цаашид төсвийн тодотгол, үүнээс улбаатай эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр зээлийн өсөлт нэмэгдэхээр байна. М2 мөнгөний өсөлтийг энэ онд гадаад цэвэр активын өсөлт болон банкны зээл голлон бүрдүүлэх хүлээлттэй байна.

Ийнхүү эдийн засгийн дотоод, гадаад орчны голлох эрсдлүүдэд үндэслэн бодлогын хүүг өсгөх болон бууруулах, төсвийн зардал нэмэгдэх, Хятадын өсөлт саарах, ханш сулрах, зээл олголт муудах гэсэн хувилбар төсөөллүүдийг танилцууллаа. Танилцуулгын төгсгөлд бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах саналыг дэвшүүлэв.

Энэ удаагийн хуралдааны хоёрдугаар хэсэгт НУСЗЗГ-аас орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хэрэгжилт, уг хөтөлбөрийг засгийн газарт шилжүүлэхтэй холбоотой эх үүсвэрийг шийдвэрлэх тухай асуудлыг танилцуулав. Манай улсад хэрэгжиж буй ипотекийн 6 хувийн хүүтэй зээл нь бусад улсуудтай харьцуулахад харьцангуй таатай нөхцлөөр хэрэглэгчид хүрдэг. Монголбанк 2013 оноос эхлэн өдийг хүртэл 7.3 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн санхүүжилтийг дангаараа болон засгийн газар, банкуудтай хамтрах байдлаар шийдвэрлэж ирсэн. Гэсэн хэдий ч энэхүү төсвийн шинжтэй төсөл хөтөлбөр нь Монголбанкны үндсэн үйл ажиллагаа болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй харшлах тул ОУВС-аас хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх санал, шаардлага тавьж Монголбанк, Засгийн газар үүнийг дэмжсээр ирсэн. Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хөтөлбөрийг шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцэж, 2020-24 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2024 онд багтаан Үндэсний орон сууцны корпорац (ҮОСК) байгуулж орон сууцны ипотекийн хөтөлбөрийг цогцоор нь шилжүүлэх шийдвэр гаргасан. Гэхдээ ҮОСК байгуулахад тодорхой хууль эрхзүйн орчин шаардлагатай тул хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барих асуудлыг Барилга хот байгуулалтын яам хариуцах, УИХ-аас хууль батлагдаад ҮОСК байгуулагдан хөтөлбөрийг шилжүүлэх хүртэл Монголбанк хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангах тал дээр хамтран ажиллаж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх тухай асуудлыг танилцууллаа.

Үргэлжлүүлээд МБХ-ны гишүүд 2024 оны Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн зорилтуудын тухай асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Нэг гишүүний зүгээс сүүлийн жилүүдэд инфляц дунд хугацааны зорилтоос өндөр түвшинд байгаа бөгөөд цаашид ч зорилтоос өндөр түвшинд байх эрсдэлтэй байгаа нь иргэдийн төв банканд итгэх илтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд инфляцын зорилтыг нэмэгдүүлж дунд хугацаанд 1 оронтой тоонд тогтоох санал дэвшүүллээ.

Харин бусад гишүүдийн зүгээс инфляцын зорилт нь жил болгон өөрчлөгдөх ёсгүй бөгөөд бодит гүйцэтгэл зорилтоос зөрүүтэй үед түүнийг ирээдүйд зорилтот түвшин рүү

тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэх ёстой гэж үзэв. Мөн инфляцын зорилт нь иргэдийн хүлээлтийг тогтворжуулах ач холбогдолтой тул зорилт өсөхөд инфляцын хүлээлт нэмэгдэх, улмаар цаашдын инфляц суурь төсөөллөөс өсөх эрсдэлтэй юм. Түүнчлэн, дэлхийн олон улс орнуудад инфляцын түвшин нь зорилтоос өндөр байгаа боловч инфляцын зорилтоо өөрчилсөн Төв банк одоогоор байхгүй байгааг дурдаж, дунд хугацааны инфляцын зорилт 6+/-2 хувьд байхыг дэмжлээ.

Хуралдааны дараагийн хэсэгт МБХ-ны гишүүд мөнгөний бодлогын саналтай холбоотойгоор эдийн засгийн цаашдын төлөв, түүнд ашигласан таамаглалт нөхцөлүүд, банкны системийн зээлийн өсөлт, нүүрсний экспорт түүний эдийн засгийн үр ашиг, төлбөрийн тэнцэлийн талаар асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Нэг гишүүний зүгээс АНУ-ын бодлогын хүү энэ онд дахиад өсөх магадлалтай байгаа нь ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх, ирэх онд сонгуулийн жил тохиохтой холбоотойгоор төсвийн зардал тэлж инфляц төсөөллөөс өндөр өсөх эрсдэлтэй байгааг харгалзан үзвэл бодлогын хүүг бага зэрэг нэмэгдүүлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч нөгөө талдаа банкуудын зээлийн хүүний өсөлт, банкны харилцагч, зээлийн эрэлт зэргийг харгалзан үзэх нь чухал тул бодлогын хүүг одоогийн түвшинд хадгалахыг дэмжихээ илэрхийлэв.

Өөр нэг гишүүний хувьд хөрш орнуудын ханш суларсан нь эдгээр улсуудаас авах импортын барааг хямд болгох, глобал инфляц саарч байгаа, дотоодын хүнсний ногооны тариалалт сайн, өмнөх жилтэй харьцуулахад тээвэрлэлт, нийлүүлэлтийн асуудал намжсан зэргээс нийт инфляц буурахаар байгаа тул ирэх оноос бодлогын хүүг бууруулж, уул уурхайн бус салбарыг дэмжих орон зай үүсэх хэрэгцээ байгааг онцлов.

Бусад гишүүдийн хувьд нэг талаас бодлогын хүүг нэмэгдүүлэх нь бизнесийн орчин, ажлын байрыг хумих замаар эдийн засгийн идэвхжилийг удаашруулах эрсдэлтэй, нөгөө талаас төсвийн төлөв суларснаар эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэхээр байгааг харгалзан бодлогын хүүг хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн байр суурийг баримтлалаа.

Үргэлжлүүлээд МБХ-ны гишүүд ипотекийн зээлийн санхүүжилтийн тухай хууль эрх зүйн үндэслэл, мөнгөний бодлогын хэрэгсэлд хамаарах эсэх асуудлаар асуулт асууж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Нэг гишүүний зүгээс ипотекийн зээлийн санхүүжилтийг Монголбанк түр хариуцах нь зарчмын хувьд зөв гэж үзлээ. Гэхдээ процессын хувьд эхлээд Засгийн газар уг хөтөлбөрийг шилжүүлэн авах бэлтгэл ажлаа бүрэн хангах хүртэлх хугацаанд Монголбанк үргэлжлүүлэн хариуцах тухай УИХ-аас тогтоол гарсаны дараа хөтөлбөрийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзээд татгалзав. Өөр нэг гишүүний хувьд ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөр нь төсвийн шинжтэй, стандарт бус мөнгөний бодлого тул уг хөтөлбөрийг үргэлжлүүлэх нь оновчгүй гэж үзэв.

Бусад гишүүдийн хувьд Монголбанк ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх тухай асуудлыг зарчмын хувьд дэмжсэн. Учир нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хууль, эрхзүйн үндэслэлтэй, тухайлбал дундаж давхаргад дэмжлэг үзүүлэх санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх хуулийн томъёололтой нийцтэй байна. Түүнчлэн, хөтөлбөрийг ТОСК, Хөгжлийн банканд шилжүүлэх тухай асуудал яригдсан боловч эдгээр байгууллагууд нь санхүүгийн хувьд тогтворгүй байгаагаас үүдэн ипотекийн санхүүжилт тасалдах эрсдэлтэй тул Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгасан ҮОСК-ыг ирэх онд байгуулан хууль эрхзүйн орчныг бүрдүүлж, хөтөлбөр хүлээн авагч тал бэлэн болох хүртэл хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангах тал дээр хамтран ажиллаж


хүлээцтэйгээр шилжүүлэн өгөх нь зарчмын хувьд зөв гэсэн байр суурьтай байв. Хөтөлбөрийг шилжүүлэхтэй холбоотойгоор 7 сараас эхлэн ипотекийн санхүүжилт олгогдохгүй байгаа нь хөтөлбөрийн хэвийн тасралтгүй байдалд хүндрэл учруулж, тулгамдсан асуудал болоод байгааг дурдлаа.

Ийнхүү 2024 оны Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг УИХ-д өргөн барих, бодлогын хүүг хэвээр хадгалах саналыг МБХ-ны нийт гишүүд 100 хувийн саналаар дэмжлээ. Ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэхтэй холбоотой эх үүсвэрийг шийдвэрлэх тухай асуудал дээр нийт 5 гишүүн санал хураалтад оролцож 2 гишүүн татгалзаж, 3 гишүүн дэмжиж олонхийн саналаар уг хөтөлбөрийг түр хугацаанд Монголбанк үргэлжлүүлэн хариуцах шийдвэр гаргалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 9 дүгээр сарын 13, 15-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:


1. Бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах
2. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барих
3. Засгийн газраас ҮОСК-ыг 2024 онд багтаан байгуулж, ипотекийн орон сууцны зээлийн хөтөлбөрийг шилжүүлэн авах хүртэл хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор Монголбанкны эзэмшиж буй ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөрийн эргэн төлөлт, банкуудын ипотекийн зээлийн олголттой уялдуулан хөтөлбөрт оролцогч банкуудад эх үүсвэр олгох шийдвэрүүдийг тус тус гаргалаа.



Бодлогын хүүг хэвээр хадгалах



2024 оны Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг УИХ-д өргөн барих



Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийг түр хугацаанд Монголбанк үргэлжлүүлэн хариуцах